



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.04 № 1/143

БАТЛАН ХАМГААЛАХ ЯМАНД

Зөрчил арилгуулах тухай

“Батлан хамгаалах салбарын Ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт болон зэвсэгт хүчний хөгжлийн сан, гадаадаас авсан хандив, тусlamжийн ашиглалтын үр дүн”-д хийсэн аудитаар “Монгол цэрэг-жуулчин” ТӨҮГ, Зэвсэгт хүчний 017 дугаар анги, Зэвсэгт хүчний 338 дугаар ангиуд нэр бүхий 5 барилга, байгууламжийн барилга угсралтын хийгдээгүй ажлыг хийгдсэн мэтээр гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх....”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Тус яаманд баригдаж буй барилга, байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд илүү санхүүжилт авсан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх” - 314.4 сая, “Тэмүүжин өрлөг” ЕБС-ын сургуулийн дотуур байрны цогцолбор - 580.2 сая, Цэргийн алба хаагчдын 16 айлын орон сууц - 76.2 сая, “Цэрэг, спорт төв цогцолбор” - 829.8 сая, “Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга”-ын барилгын өргөтгөл - 121.8 сая нийт 19022.32 сая төгрөг болсон байна. Иймд гүйцэтгэгч байгууллагууд болох “Монгол цэрэг-жуулчин” ТӨҮГ, Зэвсэгт хүчний 017 дугаар анги, Зэвсэгт хүчний 338 дугаар ангиудын илүү авсан санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж 2013 оны 12 сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга 3.Болдбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Батсүх нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР

Д.БАТТУЛГА

